



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, 9.1.3, 9.1.20, Засгийн газрын 2012 оны 49 дүгээр тогтоолоор баталсан Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2.6 дах заалтуудыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, эрчим хүчээр зохицуулалттай хангах, цахилгаан импортлох, экспортлох, эрчим хүчний барилга байгууламж барих (Эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх гэх) “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журам”-ыг 2015 оны 01 дүгээр 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Х.Эрдэнэчулуун/-нд даалгасугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

С.ОТГОНБАЯР

Д.БАССАЙХАН

Р.МЯГМАР

Т.ГАНТӨМӨР



*М.Санжир*



## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, эрчим хүчээр зохицуулалттай хангах, цахилгаан импортлох, экспортлох, эрчим хүчний барилга байгууламж барих, диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/-ийг хуулийн этгээдэд олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, өөрчлөх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйл ажиллагаа нь Эрчим хүчний зохицуулах хороо /цаашид "ЭХЗХ" гэх/-ноос баталсан Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэлд нийцсэн байна.

1.3 Энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг тусгай зөвшөөрөл олгогч болон хүсэлт гаргагч хуулийн этгээд нэгэн адил дагаж мөрдөнө.

### Хоёр. Тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах

2.1 Эрчим хүчний тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргагч хуулийн этгээд нь Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан уг журмын хавсралтад заасан баримт бичгийг бүрдүүлсэн байна.

2.2 Эрчим хүчний тусгай зөвшөөрөл авах өргөдлийг ЭХЗХ-ны [www.erc.mn](http://www.erc.mn) цахим хуудасны Тусгай зөвшөөрлийн цахим системд хандаж онлайнаар гаргах ба тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах мэдээллийг (цаашид цахим систем гэх)-д оруулж бүртгүүлнэ.

2.3 Тусгай зөвшөөрлийн цахим системд онлайнаар гаргасан мэдээллийн үнэн зөв болохыг хуулийн этгээд бүрэн хариуцна.

2.4 ЭХЗХ-ны тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан хэлтэс тухайн хуулийн этгээдийн онлайнаар бүртгүүлсэн өргөдөл, мэдээллийн иж бүрдлийн үнэн зөв байдлыг хянах ба шаардлага хангасан өргөдлийг хүлээн авч баталгаажуулна.

2.5 Цахим системд бүртгүүлсэн мэдээлэл алдаатай, зөрүүтэй, чанарын шаардлага хангаагүй нөхцөлд мэдээллийг тодруулах буюу засварлуулахаар буцаах ба мэдээлэл үнэн зөв бүрдэх хүртэл тусгай зөвшөөрлийн өргөдөл баталгаажихгүй.

2.6 Тусгай зөвшөөрлийн цахим системээс хуулийн этгээдийн өргөдлийг баталгаажуулсан талаар мэдээлэл ирэхэд тусгай зөвшөөрөл хүсэгч дараах баримт материалыг эх хувиар ЭХЗХ-нд ирүүлнэ. Тусгай зөвшөөрлийн эх баримт материал хуулийн этгээдийн захирал /дарга/-ын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан байх ба бүх баримт материалын хуудас дугаарлагдсан байна.

2.6.1 Тусгай зөвшөөрлийн өргөдөл

2.6.2 Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

2.6.3 Техник эдийн засгийн үндэслэл

2.6.4 Байгаль орчны үнэлгээ

2.6.5 Санхүүгийн тайлан тэнцэл

## **2.6.6 Боловсон хүчний мэдээлэл**

2.7 Тусгай зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийн иж бүрдлийг нягтлан шалгах явцад дараах нөхцөл байдал баримтаар нотлогдвол тусгай зөвшөөрлийн өргөдлийг Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дах заалтын дагуу 10 хоногийн дотор өргөдөл гаргагчид буцаана.

- 2.7.1 Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг нотлох баримт бичиг зөрчилтэй, улсын бүртгэлийн байгууллагын мэдээллээс зөрсөн.
- 2.7.2 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг эрхлэхэд тавигдах босго үзүүлэлтийг хангаагүй.
- 2.7.3 Цахилгаан, дулаан дамжуулах болон диспетчерийн зохицуулалт эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд Эрчим хүчний тухай хуулийн 14.3, 15.3 заалтад хамаарах тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл ирүүлсэн.
- 2.7.4 Тусгай зөвшөөрлийн өргөдөл, эх баримт материалын иж бүрдэл дутуу буюу Тусгай зөвшөөрлийн цахим системд бүртгүүлсэн мэдээллээс зөрсөн.
- 2.7.5 Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан тоо, мэдээлэл, баримт материал зөрүүтэй, алдаатай.

2.8 ЭХЗХ-ны тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан хэлтэс хуулийн этгээдийн ирүүлсэн эх баримт материалын иж бүрдэл, онлайн системд бүртгүүлсэн мэдээллэлтэй тохирч байгаа эсэхийг нягтлан шалгах ба эх баримт бичгийн иж бүрдэл шаардлага хангасан өргөдлийг үнэлэх шатанд шилжүүлнэ.

2.9 Тусгай зөвшөөрлийн цахим системд хандан өргөдөл гаргах, мэдээлэл оруулах, ЭХЗХ-ны холбогдох нэгктэй цахимаар харилцах, мэдээлэл солилцох заавар, гарын авлагыг ЭХЗХ-ны цахим хуудаст байрлуулсан байна.

## **Гурав. Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг үнэлэх, хянан шийдвэрлэх**

3.1 Эх баримт бичгийн бүрдэл шаардлага хангаж үнэлэх шатанд шилжсэн өргөдлийг Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 заасны дагуу хуанлийн 60 хоногийн дотор Хорооны хурлаар үе шаттай хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулна.

3.2 ЭХЗХ-ны тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан хэлтэс нь хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх чадамжийг дараах тулгуур асуудлуудын хүрээнд үнэлж дүгнэлт гаргана.

- 3.2.1 Эрчим хүчний хангамж хэрэглээний тэнцлийг хангасан байдал
- 3.2.2 Техник, технологийн шийдэл нь үр ашигтай, аюулгүй, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх шаардлагыг хангасан байдал
- 3.2.3 Эдийн засгийн орчин, үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж
- 3.2.4 Тухайн үйл ажиллагааг эрхлэн явуулах санхүүгийн чадавхи
- 3.2.5 Аюулгүй ажиллагааны менежментийг шийдвэрлэсэн байдал
- 3.2.6 Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд нөлөөлөх байдал
- 3.2.7 Хэрэглэгчдэд бий болох эерэг болон сөрөг үр нөлөө

3.3 Энэхүү журмын 3.1.1-3.1.3-д заасан нөхцөлүүд бүрдсэн эсэхийг техник эдийн засгийн үндэслэлийг тодорхойлсон албан ёсны баримт бичигт үндэслэн үнэлнэ.

3.4 Санхүүгийн чадавхыг санхүүгийн тайлан тэнцэл, аудитын байгууллагын дүгнэлтэд үндэслэн үнэлнэ. Татварын байгууллагад ихээхэн хэмжээний өр төлбөртэй байх болон татварын аливаа зөрчилд холбогдож байсан эсэх мэдээлэл нь санхүүгийн чадавхыг үнэлэхэд харгалзах хүчин зүйл

болно.

3.5 Хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн өргөдөл аюулгүй ажиллагааг хангаж ажиллах үйл ажиллагааны зохион байгуулалт, менежмент, хүний нөөцийн талаар мэдээллийг танилцуулсан байна.

3.6 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг эрхлэх боломжтой эсэх нөхцөл байдлыг үнэлэх, нягтлах зорилгоор ЭХЗХ-ны холбогдох ажилтан хуулийн этгээдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах эрхтэй.

3.7 Тусгай зөвшөөрлийн өргөдлийг үнэлэх шатанд зарим мэдээллийг нягтлах, баталгаажуулах шаардлага үүсвэл нэмэлт материал шаардаж болох ба өргөдөл гаргагч хуулийн этгээд тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

3.8 Хорооны хурлаас хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн бол уг шийдвэрийг Тусгай зөвшөөрлийн цахим системээр мэдээлнэ.

3.9 Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр гарсан бол энэ тухай өргөдөл гаргагч хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэх ба уг албан бичигт тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан үндэслэлийг дурдсан байна.

3.10 Тусгай зөвшөөрлийн өргөдөл, баримт материалыг үнэлэх шатанд хийсэн дүгнэлтэд үндэслэн дараах нөхцөлд тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах шийдвэр гаргана.

- ✓ Тусгай зөвшөөрлийн талаар баримтлах Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэлд нийцээгүй;
- ✓ Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулах техникийн болон эдийн засгийн боломж, нөхцөл хангагдаагүй буюу бүрдээгүй;
- ✓ Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулах санхүүгийн чадавхгүй;
- ✓ Боловсон хүчний чадавхи, хүрэлцээ шаардлага хангаагүй;
- ✓ Аюулгүй ажиллагааны зохион байгуулалт, менежмент нарийн төлөвлөгдөөгүй ;
- ✓ Хуурамч баримт материал бүрдүүлсэн, худал мэдээлэл өгсөн;
- ✓ Хуульд заасан бусад үндэслэл;

3.11 Энэхүү журмын 3.10-д заасан дүгнэлтийг өргөдөл гаргагч хуулийн этгээд үл зөвшөөрсөн тохиолдолд ЭХЗХ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, хэрэглэгчийн хэлтэст хандаж дүгнэлт гаргуулж болно.

3.12 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн оноосон нэр, байгууллагын дүрэм, тусгай зөвшөөрлийн нөхцөл өөрчлөгдсөн зэрэгтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийг шинэчлүүлэх талаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш ЭХЗХ-ны тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан хэлтэс хуанлийн 30 хоногийн дотор ЭХЗХ-ны хурлаар үе шаттай хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.13 Хуулийн этгээд нь олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гээсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн, ашиглах боломжгүй шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол нотлох баримтыг үндэслэн ЭХЗХ-ны даргын шийдвэрээр гэрчилгээг нөхөн олгоно.

## Дөрөв. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага

4.1 Хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоходо үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох ба тусгай зөвшөөрөл эзэмшигч дагаж мөрдөх үүрэгтэй.

4.2 ЭХЗХ нь тусгай зөвшөөрлийн ерөнхий нөхцөл, шаардлагын хүрээнд тухайн онд мөрдөж ажиллах үйл ажиллагааны шаардлага, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг жил бүр тогтоож Тусгай зөвшөөрлийн цахим системд байрлуулна.

4.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд энэ журмын 4.2-д заасан үйл ажиллагааны шаардлага, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг Тусгай зөвшөөрлийн цахим системд онлайнаар тайлагнана.

4.4 ЭХЗХ-нд ирүүлсэн тусгай зөвшөөрлийн шаардлагын биелэлт үнэн зөв болохыг хуулийн этгээд бүрэн хариуцна.

4.5 ЭХЗХ-ны Тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан хэлтэс нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн шаардлагын биелэлтийг маягтын дагуу онлайнаар болон бичгээр авч жил бүр тогтоосон аргачлалын дагуу дүгнэж, мэдээллийн санд бүртгэнэ.

#### **Тав. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах**

5.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Эрчим хүчний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа дуусахаас 180-аас доошгүй хоногийн өмнө тусгай зөвшөөрөл сунгуулах өргөдлийг ЭХЗХ-ны [www.erc.mn](http://www.erc.mn) цахим хуудасны Тусгай зөвшөөрлийн цахим системд хандаж онлайнаар гаргах ба тусгай зөвшөөрөл сунгахад шаардагдах мэдээллийг цахим системд оруулж бүртгүүлнэ.

5.2 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг тогтоосон үзүүлэлтийн дагуу жил бүр дүгнэсэн тайлан нь тусгай зөвшөөрлийн сунгах эсэх асуудлыг шийдвэрлэхэд голлох үзүүлэлт болно.

5.3 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зохих ёсоор биелүүлсэн бөгөөд техник, технологи, эдийн засаг, санхүүгийн хувьд цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл боломжтой гэж дүгнэгдсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг ЭХЗХ нь Эрчим хүчний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д заасны дагуу 25 хүртэл жилээр сунгана.

5.4 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлт хангалтгүй, үйл ажиллагааны үзүүлэлт зохицой төвшинд хүрээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, дүгнэлт гаргасны үндсэн дээр тусгай зөвшөөрөл сунгах, эсэх асуудлыг ЭХЗХ-ны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

5.5 Олгосон тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, нөхцөл, шаардлага өөрчлөгдсөн, болон эрчим хүчний барилга байгууламж баригдаж дууссан талаарх мэдээллийг ЭХЗХ-ны [www.erc.mn](http://www.erc.mn) цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

#### **Зургаа. Тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа**

6.1 Тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хорооны тогтоол, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хамт ажлын 10 хоногт багтаан олгоно.

6.2 Хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн гэрчилгээг авахаас өмнө улсын тэмдэгтийн хураамжийн төлбөр, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан үйлчилгээний төлбөр, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг ЭХЗХ-нд төлсөн байна.

6.3 Тусгай зөвшөөрөл олгосон болон олгохоос татгалзсан, хугацааг нь сунгасан, тусгай зөвшөөрлийг шинэчилсэн, нөхөн олгосон тухай мэдээлэл Тусгай зөвшөөрлийн цахим системд бүртгэгдэж, тухай бүр мэдээлэгдэнэ.

#### **Долоо. Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх, сэргээх**

7.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Эрчим хүчний тухай хууль болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд ЭХЗХ-ноос зөрчлийг

арилгах тухай хугацаатай үүрэг өгнө. Заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй бол эрчим хүчний хяналтын улсын байцаагч тусгай зөвшөөрөл эзэмшигчид зохих шийтгэл ногдуулж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг З хүртэл сараар түдгэлзүүлж болно.

7.2 ЭХЗХ нь түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д заасны дагуу З хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

7.3 Тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд ЭХЗХ-ны хурлын шийдвэрээр тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

#### **Найм. Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох**

8.1. ЭХЗХ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хуулиудад заасан дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

- 8.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
- 8.1.2. тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;
- 8.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, дампуурсан;
- 8.1.4. тусгай зөвшөөрлийг хууль бусаар олж эзэмшсэн нь тогтоогдсон;
- 8.1.5. энэ журмын 6.1-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн боловч зөрчлийг хугацаанд нь арилгаагүй;
- 8.1.6. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;
- 8.1.7. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг биелүүлээгүй буюу байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн;

8.2 ЭХЗХ тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид өгснөөс хойш Эрчим хүчний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д заасны дагуу 30 хоногт багтаан хүчингүй болгосон шийдвэр гаргана.

8.3 Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар ЭХЗХ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д заасны дагуу шийдвэр гарснаас хойш З хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд бичгээр мэдэгдэнэ.

8.4 Тусгай зөвшөөрлийн хүчингүй болсон нь түүнийг эзэмшигч хуулийн этгээдийн байгаль орчныг нөхөн сэргээх болон бусад үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

8.5 Тусгай зөвшөөрөл олгогч тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх найдвартай ажиллагааг хангах, хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийг тасалдуулахгүй байх үүднээс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчээр энэхүү үйл ажиллагааг гүйцэтгүүлж болно.

#### **Ес. Хориглох үйл ажиллагаа**

9.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

- 9.1.1 Тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэх;
- 9.1.2 Тусгай зөвшөөрлөөр олгогдсон монополь эрхээ хууль бусаар ашиглах;

- 9.1.3 Эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэхдээ бусад тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчдийг ялгаварлан гадуурхах;
- 9.1.4 Эрчим хүчний тусгай зөвшөөрлөөр эрхэлж байгаа үйл ажиллагаанд хор хохирол, аюул эрсдэл учруулж болохуйц бусад үйл ажиллагаа эрхлэх;

#### **Арав. Бусад зүйл**

10.1 ЭХЗХ-ны тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан хэлтэс нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талаарх мэдээллийг шинэчлэх, баяжуулах, холбогдох өөрчлөлтийг хийх, мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, байгууллага, иргэдийг мэдээллээр хангаж ажиллана.

10.2 Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байна.

10.3 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, түүний биелэлтэд хяналт тавих, дүгнэх, тайлан мэдээ гаргах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хийж тэдгээрийн үр дүнг ЭХЗХ, Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах, мэдээллээр хангах ажлыг ЭХЗХ-ны Тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан хэлтэс хариуцна.

-----оОо-----

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрөл шинээр авахад бүрдүүлэх бичиг баримт
1	Цахилгаан, дулаан үйлдвэрлэх	<ol style="list-style-type: none"> <li>Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл</li> <li>Улсын бүртгэлийн гэрчилгээ</li> <li>Техник, эдийн засгийн үндэслэл</li> <li>Үйлдвэрлэх эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт</li> <li>Үйл ажиллагаандaa ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт</li> <li>Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл</li> <li>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</li> <li>Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</li> <li>Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи</li> <li>Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага</li> </ol>
2	Цахилгаан дамжуулах	<ol style="list-style-type: none"> <li>Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл</li> <li>Улсын бүртгэлийн гэрчилгээ</li> <li>Техник, эдийн засгийн үндэслэл</li> <li>Дамжуулах цахилгааны төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт</li> <li>Үйл ажиллагаандaa ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт</li> <li>Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл</li> <li>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</li> <li>Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</li> <li>Санхүүгийн нөөц, эдийн засгийн чадавхи</li> <li>Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага.</li> </ol>
3	Дулаан дамжуулах	<ol style="list-style-type: none"> <li>Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл</li> <li>Улсын бүртгэлийн гэрчилгээ</li> <li>Техник, эдийн засгийн үндэслэл</li> <li>Дамжуулах дулааны төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт</li> <li>Үйл ажиллагаандaa ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт</li> <li>Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл</li> <li>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</li> <li>Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</li> <li>Санхүүгийн нөөц, эдийн засгийн чадавхи</li> <li>Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага.</li> </ol>
4	Диспетчерийн зохицуулалт хийх	<ol style="list-style-type: none"> <li>Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл</li> <li>Улсын бүртгэлийн гэрчилгээ</li> <li>Техник, эдийн засгийн үндэслэл</li> <li>Эрчим хүч дамжуулахад ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа</li> <li>Эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт</li> <li>Үйл ажиллагаандaa ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт</li> <li>Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл</li> <li>Санхүүгийн нөөц, эдийн засгийн чадавхи</li> </ol>

		8. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага.
5	Цахилгаан, дулаан түгээх	1. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл 2. Улсын бүртгэлийн гэрчилгээ 3. Техник, эдийн засгийн үндэслэл 4. Түгээх эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт 5. Үйл ажиллагаандaa ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт 6. Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл 7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ 8. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 9. Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи 10. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага
6	Эрчим хүчээр зохицуулалттай хангах	1. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл 2. Улсын бүртгэлийн гэрчилгээ 3. Техник эдийн засгийн үндэслэл 4. Хангах эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт 5. Үйл ажиллагаандaa ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт 6. Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл 7. Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи 8. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага
7	Цахилгаан импортлох, экспортлох	1. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл 2. Улсын бүртгэлийн 3. Техник, эдийн засгийн үндэслэл 4. Импортлох, экспортлох цахилгааны төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт 5. Үйл ажиллагаандaa ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт 6. Санхүүгийн нөөц, эдийн засгийн чадавхи 7. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага.
8	Эрчим хүчний барилга байгууламж барих	1. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл 2. Улсын бүртгэлийн гэрчилгээ. 3. Техник, эдийн засгийн үндэслэл 4. Эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт 5. Үйл ажиллагаандaa ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт 6. Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл 7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ 8. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 9. Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи 10. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага

-----оОо-----